



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2025.05.13 № 05/9121
танай _____ -ны № _____ -т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Д.ОЮУНБОЛД
ТАНАА

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын Ерөнхий инженерийн албан тушаалд томилогдоо нэр дэвшсэн Яндагийн Өнөртүвшин, Дотоод аудитын албаны даргын албан тушаалд томилогдоо нэр дэвшсэн Нямдаваагийн Баатардэмбэрэл, Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн даргын албан тушаалд томилогдоо нэр дэвшсэн Эрдэнэбаярын Балт, Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн тооцооны нягтлан бодгчийн үүргийг хавсран гүйцэтгэгчээр томилогдоо нэр дэвшсэн Ууганбаярын Сүнжидмаа нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Нямдаваагийн Баатардэмбэрэлийн нь хамаарал бүхий этгээд буюу төрсөн дүү Н.Батдэмбэрэл нь Авто зам, замын байгууламжийг барих, засварлахад техник технологийн хяналт тавих тусгай зөвшөөрөл, Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах тусгай зөвшөөрөл, Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл, Төмөр замын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй “Ангад арвижих” ХХК-ийн өмчлөгч, захирлаар бүртгэлтэй байх тул тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



142503010748



165203030348